



1. Дараах компьютерын бүрэлдэхүүн хэсгүүд болон төхөөрөмжүүдээс гаралтын төхөөрөмжүүдээс бүрдсэн багцыг сонгоно уу.

A.	 хатуу диск	 дууны карт	 шуурхай санах ой	 дигитал камер
B.	 проектор	 дэлгэц	 принтер	 чанга яригч
C.	 микрофон	 сканер	 гар	 хулгана
D.	 дэлгэц	 микрофон	 принтер	 чанга яригч

2. Компьютерын тооны машин ашиглан тоо бодоход хариу нь удаан гарч ирдэг бол ямар төхөөрөмж хэвийн бус ажиллаж байна вэ?



- A. Оролтын төхөөрөмж (Keyboard)
B. Гаргалтын төхөөрөмж (Monitor)
C. Төв боловсруулах байгууламж (CPU)
D. Гадаад хадгалах төхөөрөмж (External hard drive)

3. 11а ангийн сурагчид MS PowerPoint программ дээр “Компьютер гэж юу вэ?” гэсэн гарчгийг бичиж оруулав. Энэ үед компьютерын CPU нь бичвэрийн мэдээллийг санах ойд ямар форматаар хадгалах вэ?

- A. 1 ба 2 B. 0 ба 2 C. Компьютер гэж юу вэ? D. 0 ба 1

4. Проектороор бүх төрлийн видео болон тоглоом зэргийг тоглуулж байгаа тохиолдолд дэлгэцийн форматыг аль болох өргөн (wide screen) байлгах шаардлагатай. Тэгвэл доорх стандартуудаас аль нь өргөн дэлгэцийнх вэ?

- A. UXGA 1920 x 1200
B. SXGA+ 1400 x 1050
C. XGA 1024 x 768
D. WXGA 1280 x 800

5. Сурагч интернэтээс мэдээлэл хайхдаа компьютерын гар болон хулгана ашиглан Google Chrome хөтөч ашиглан хайлт хийж, гарсан үр дүнг дэлгэц дээр уншив. Дээрх үйл явц нь компьютерын техник хангамж, программ хангамж, хэрэглэгч хоорондын уялдаа холбоог хэрхэн илэрхийлж байгаа зөв дүгнэлтийг сонгоно уу.

- A. Оролтын төхөөрөмжөөр мэдээлэл оруулж, техник хангамжийн төхөөрөмжүүд программ хангамжийн оролцоогүйгээр бие даан боловсруулсан
- B. Мэдээлэл оруулсан боловч бүх үйлдлийг программ хангамж хэрэглэгчийн оролцоогүйгээр гүйцэтгэсэн
- C. Оролтын төхөөрөмжөөр мэдээлэл оруулж, программ хангамж боловсруулан, гаралтын төхөөрөмжөөр үр дүнг харуулсан
- D. Мэдээлэл оруулсан боловч зөвхөн гаралтын төхөөрөмж мэдээллийг боловсруулж хэрэглэгчид дамжуулсан

6. Сурагч шинэ дууны карт (sound card)-ыг компьютерт суулгаж, чанга яригчийг зөв холбосон боловч дуу нь сонсогдохгүй байв. Дууны картыг хэвийн ажиллуулахын тулд хамгийн түрүүнд юуг шалгах вэ?



- A. Чанга яригч зөв холбогдсон эсэх болон дууны гаралтын төхөөрөмж зөв сонгогдсон эсэх
- B. Хэрэглээний программ (media player) шинэчлэгдсэн эсэх
- C. Компьютерын дэлгэцийн нягтралыг зөв тохируулсан эсэх
- D. Үйлдлийн системд тохирох дууны картын драйвер суусан эсэх

7. Сурагч бие даалтаараа хийсэн веб хуудас болон веб хуудсандаа оруулсан зураг, бичлэг зэргийг нэгтгэн багш руугаа илгээх шаардлагатай болов. Тэрээр ямар программ ашиглаж асуудлаа шийдвэрлэх вэ?

- A. Scan Disk
- B. McAfee
- C. Winzip
- D. Undelete


8. Дараах программуудыг үүрэгтэй нь зөв харгалзуулна уу.

Программ		Үүрэг	
1.	Defragment and Optimize Drives	A.	Хатуу дискийг цэвэрлэх
2.	Disk Cleanup	B.	Файл, программ хангамжийг өөр төхөөрөмж дээр нөөцлөн хадгалах
3.	Device Manager	C.	Хатуу диск дээрх файлыг дахин зохион байгуулж хадгалах
4.	Backup	D.	Компьютерт суулгасан үндсэн болон дагалдах төхөөрөмжүүдийн талаарх системийн мэдээлэл харуулах

- A. 1c, 2a, 3b, 4d
- C. 1c, 2d, 3a, 4b


- B. 1a, 2c, 3d, 4b
- D. 1c, 2a, 3d, 4b

9. Бүдүүвчид үзүүлсэн веб сайтын мэдээллийн бүтцийг зөв тодорхойлсон хэсгийг сонгоно уу.



- A. Шаталсан B. Цикл ба шаталсан C. Шугаман D. Цикл

10. Веб хөтчийн таб дээр веб хуудасны нэрийг зурагт үзүүлсэн шиг харуулахын тулд HTML-ийн аль тагийг ашиглах вэ?



- A. `<h1> Миний веб хуудас </h1>`
 B. `<title> Миний веб хуудас </title>`
 C. `<body> <title> Миний веб хуудас </title> </body>`
 D. `<head> <h1> Миний веб хуудас </h1> </head>`
11. Сургуулийн веб сайтад хэрэглэгчийг өөр хуудас руу шилжүүлэх холбоос үүсгэх шаардлагатай болов. Дараах кодын аль нь зөв бэ?
- A. `<a href="https://medle.mn">medle.mn</a>`
 B. `<a url="https://medle.mn">medle.mn</a>`
 C. `<href="https://medle.mn">medle.mn</href>`
 D. `<link href="https://medle.mn">medle.mn</link>`
12. CSS дүрмийн бүтэц нь сонгогч (selector), шинж чанар (property), утга (value) гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Дараах өгөгдлийг зөв ангилсныг сонгоно уу.

Өгөгдөл

1. p
2. font-style
3. italic

- A. 1–selector, 2–property, 3–value
 B. 1–property, 2–selector, 3–value
 C. 1–value, 2–property, 3–selector
 D. 1–selector, 2–value, 3–property

13. External, internal, inline CSS-ийн гурван аргыг зөв ашигласан HTML кодыг сонгоно уу.

A.	<pre><html> <head> <style>h2 {color:red}</style> </head> <body style="background-color:grey"> <link rel="stylesheet" href="style.css"> <h2>Мэдээллийн технологи</h2> </body> </html></pre>	B.	<pre><html> <head> <link rel="stylesheet" href="style.css"> <style>h2 {color:red}</style> </head> <body> <h2 style="color:red">Мэдээллийн технологи</h2> </body> </html></pre>
C.	<pre><html> <head> <link rel="stylesheet" href="style.css"> </head> <body style="background-color:grey"> <style>h2 {color:red}</style> <h2>Мэдээллийн технологи</h2> </body> </html></pre>	D.	<pre><html> <head> <link rel="stylesheet" href="style.css"> <style>h2 {color:red}</style> </head> <body style="background-color:grey"> <h2>Мэдээллийн технологи</h2> </body> </html></pre>

14. Зарим үед хуудас дахь мэдээлэл нэлээд урт байх үед түүнийг бүлэг хэсэгт холбоос хийж өгдөг ба үүнийг зангуу ашиглах гэнэ. Доорх HTML код дахь зангуу холбоосны элементүүдийг зөв утгатай харгалзуулна уу.

<pre><html> <body> < 1 href=" 2 " > 3 < 4 > </body> </html></pre>	A.	#жишээ1
	B.	a href
	C.	a
	D.	/a
	E.	“жишээ”
	F.	Жишээ 1

- A. 1-d, 2-b, 3-e, 4-d
B. 1-b, 2-e, 3-f, 4-d
C. 1-c, 2-a, 3-f, 4-d
D. 1-b, 2-a, 3-f, 4-d

15. Веб хөтчийн цонхыг тохирох харьцаагаар 3 хэсэг бүхий фрейм хуудаст хуваажээ. Дараах үр дүнг гаргах кодыг зөв дараалалд оруулан эрэмбэлнэ үү.

Фрейм үүсгэх HTML кодын үр дүн	<HTML> 1. <FRAMESET cols="60%, 40%"> 2. <FRAMESET rows="45%, 55%"> 3. <FRAME src="Index.html"> 4. <FRAME src="surah bichig_HTML.pdf"> 5. <FRAME src="learn_HTML.mp4"> </FRAMESET> </HTML>
---------------------------------------	--


A. 1, 2, 3, 4, 5

B. 1, 3, 2, 5, 4

C. 1, 3, 2, 4, 5

D. 2, 1, 3, 4, 5

16. Дараах зурагт үзүүлсэн веб хуудсыг үүсгэхэд HTML тагуудад тохирох утгуудыг зөв харгалзуулна уу.



HTML кодын үр дүн

```

<html>
<head>
  <title>ВЕБ ТЕХНОЛОГИ</title>
</head>
<body
  1
  <h1
    2
    <font
      3
      Веб программчлалын хэлний
      тухай судалцгаая.
    </font>
  </h1>
  <pre
    4
    | Ерөнхий мэдээлэл | HTML | CSS |
    PHP | JavaScript |
  </pre>
</body>
</html>
  
```

A. align="center" title="Веб сайтын нэр"

B. bgcolor="#F5FFFA" align="center"

C. color="green" face="Arial" size="6"

D. style="font-size: 20px"


A. 1b, 2a, 3d, 4c

B. 1b, 2a, 3c, 4d

C. 1a, 2b, 3d, 4c

D. 1c, 2d, 3a, 4b

17. Дараах блок схемийн гүйцэтгэх үйлдлийг илэрхийлсэн бодлогын өгүүлбэрийг сонгоно уу.



- A. Өгөгдсөн n тоо тэгш, эсвэл сондгой эсэхийг олоорой.
- B. Өгөгдсөн n тооны цифруудийн нийлбэрийг олоорой.
- C. 1-ээс n хүртэлх тоонуудын нийлбэрийг олоорой.
- D. 1-ээс n хүртэлх тэгш тоонуудын нийлбэрийг олоорой.

18. Дараах кодын үр дүнг зөв дараалалд оруулна уу.

<pre> a тоог оруулна уу 5 a+5= 10 Program has ended. </pre> Кодын үр дүн	1. <code>TextWindow.WriteLine("a+5= " + (a+5))</code> 2. <code>TextWindow.WriteLine("a тоог оруулна уу")</code> 3. <code>a= TextWindow.ReadNumber()</code>
---	--

A. 2, 3, 1

B. 3, 2, 1

C. 1, 2, 3

D. 2, 1, 3

19. Дараах код гараас ямар утга авахыг сонгоно уу.

`a = TextWindow.ReadNumber()`

- A. зөвхөн бутархай тоо
- B. зөвхөн бүхэл тоо
- C. бутархай, бүхэл тоо
- D. үсэг болон тэмдэгт

20. Small Basic хэл дээрх дараах код ажиллахад дэлгэцэд ямар үр дүн хэвлэгдэх вэ?

```

name = "Bat"
TextWindow.WriteLine("Student: " + name)
  
```

- A. Student: name
- B. Student = Bat
- C. Student: Bat
- D. Student: + Bat

21. Дараах код ажиллах үед $b = 3.5$ гэж оруулбал дэлгэцэд ямар үр дүн гарах вэ?

```
a = 6
TextWindow.WriteLine("b тоог оруулна уу")
b = TextWindow.ReadNumber()
b = Math.Floor(b)
a = a + b
TextWindow.WriteLine(a)
```

- A. 6
- B. 9
- C. 9.5
- D. 10

22. Дараах Small Basic кодыг ажиллуулах үед алдаа гарав. Кодыг зөв ажиллуулахын тулд ямар өөрчлөлт хийх шаардлагатай вэ?

```
a = 8
If a > 5 Then
    TextWindow.WriteLine(a)
```

- A. If a > 5 Then мөрийг устгах
- B. TextWindow.WriteLine(a) мөрийг TextWindow.WriteLine(a) болгох
- C. Кодын төгсгөлд EndIf мөр нэмэх
- D. a = 8 мөрийг a = 5 болгон өөрчлөх

23. Дараах кодыг ажиглаад $n = 7$ үед дэлгэцэд хэвлэгдэх хариуг сонгоно уу.

```
1. TextWindow.Write("n = : ")
2. n = TextWindow.ReadNumber()
3. sum = 0
4. For i = 1 To n
5.     If Math.Remainder(i, 2) = 1 Then
6.         sum = sum + i
7.     EndIf
8. EndFor
9. TextWindow.WriteLine("1-с " + n + " хариу= " + sum)
```

- A. 12
- B. 16
- C. 28
- D. 49

24. Дараах анхны тоо мөн эсэхийг олох программын кодыг ажиглан алдаатай мөрийг олж засна уу.

```
1. TextWindow.Write("shalgah too: ")
2. n = TextWindow.ReadNumber()
3. i = 2
4. k = 2
5. While i < n
6.   If Math.Remainder(n, i) = 0 Then
7.     k = k + 1
8.   EndIf
9.   i = i + 1
10. EndWhile
11. If k = 0 Then
12.   TextWindow.WriteLine(n + " ni ankhonii too mun.")
13. Else
14.   TextWindow.WriteLine(n + " ni ankhonii too bish.")
15. EndIf
```

- A. 6-р мөр: If Math.Float(n, 1)=0 Then байна
- B. 9-р мөр: n=n-1
- C. 11-р мөр: if k=1 Then байна
- D. 4-р мөр: k=0 байна

25. Дараах кодыг ажиглаад хувьсагчийн үр дүнг кодтой нь зөв харгалзуулна уу.

```
1 pi=3.14
2 a=pi/10
3 b=Math.Floor(a)
4 c=Math.Remainder(pi,10)
5 d=Math.Floor(pi)
```

1. 3	A. <code>d=Math.Floor(pi)</code>
2. 0	B. <code>c=Math.Remainder(pi,10)</code>
3. 3.14	C. <code>b=Math.Floor(a)</code>
4. 0.314	D. <code>a=pi/10</code>

- A. 1a, 2b, 3c, 4d
- B. 1a, 2c, 3b, 4d
- C. 1c, 2a, 3b, 4d
- D. 1c, 2d, 3a, 4b